



# “Цагаан идээ” Сэлэнгэ аймгийн Сант сум. А.Мөнхтуяа

## 2020 он

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 оны 9-12 сар

### Төсөл хэрэгжсэн газар

Сэлэнгэ аймгийн Сант сум,  
Хушаат 2-р баг

- Цагаан идээ борлуулж, олсон орлогоор малын өвс тэжээлийн нөөцөө бэлтгэсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 500,000 ТӨГ:

хийж, 1 орчим төгрөгийн ашиг олсон.

### Төслийн зорилго

Сүүн цагаан идээ боловсруулж, борлуулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх

### Төслийн хөрөнгө оруулалт

Төслийн нийт хөрөнгө оруулалт 1.000,000 төгрөг болсоноос “Ногоон алт” төслөөс 500,000 төгрөг, өөрсдөөс 500,000 төгрөг гаргаж санхүүжүүлсэн.

### Төслийн зорилтууд

- Малынхаа сүү, саалийг боловсруулан, төрөл бүрийн цагаан идээ бэлтгэх.
- Цагаан идээг зах зээлд борлуулан орлого, ашиг олох



Ааруул хатааж байгаа нь

|   | Хөрөнгө оруулалты эх үүсвэр | Санхүүжилт |
|---|-----------------------------|------------|
| 1 | НАМЭМ төслөөс               | 500.000    |
| 2 | Өөрсдөөс                    | 500,000    |
|   |                             | 1.000.000  |

### Үйл ажиллагаа

- Сүүг уламжлалт аргаар боловсруулж, ааруул, цагаан идээ бэлтгэсэн
- Бэлтгэсэн ааруулыг Дархан хотын зах зээлд борлуулсан

### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төлөвлөсөн хөрөнгийг 100 хувь үр дүнтэй зарцуулсан.

Сүүг боловсруулж, ааруул, аарц, өрөм, шар тос хийн, зах зээлд дээр 2,2 сая төгрөгийн борлуулалт



Ааруул бэлтгэсэн байдал

### Төслийн санхүүжилтын зарцуулалт

Төслийн санхүүжилт 100 хувьтай зарцуулагдсан.

Төслийн санхүүжилт болох 500.000 төгрөгийн дэмжлэгийг

НАМЭМ- төслөөс 9-р сард авч, өөрсдөөс мөн 500.000 төгрөгийг гаргаж, тэдгээрийг төслийн дагуу зарцуулсан.

### СУРГАМЖ

Сүү боловсруулах, ааруул, цагаан идээ бэлтгэх, хатаах, түр хадгалах зориулалтын боловсронгуй байр, төхөөрөмж шаардлагатай байсан.

### Хөрөнгө оруулалтын зарцуулалт

|   | Хөрөнгө оруулалтын зарцуулалт          | Хэмжих нэгж | Тоо | Нэгжийн үнэ | Дүн       |
|---|--|-------------|-----|-------------|-----------|
| 1 | Сүү боловсруулах, ааруул хийх          | килограмм   | 250 |             | 800,000   |
| 2 | Бусад зардал. /түлээ, тээврийн зардал/ | килограмм   |     |             | 200.000   |
|   | Дүн                                    |             |     |             | 1,000,000 |

### Борлуулалт, үйлчилгээний орлого

|   | Бүтээгдэхүүн | Хэмжээ    | Тоо | Худалдах нэгжийн үнэ | Борлуулалт | Ашиг    |
|---|--------------|-----------|-----|----------------------|------------|---------|
| 1 | Ааруул       | килограмм | 200 | 9,000                | 1,800,000  | 800,000 |
| 2 | Өрөм         | килограмм | 50  | 8.000                | 400.000    | 100.000 |
|   |              |           |     |                      | 2,200,000  | 900,000 |

### ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарсан. Үүнд:

- ↑ Сүү саалиа боловсруулж, цагаан идээ, ааруул, өрөм боловсуулж, зах зээлд борлуулан 900 мянган төгрөгийн ашиг олсон.
- ↑ Өрхийн орлогоо нэмэгдүүлсэн мөнгөн орлогоо намар хадлан өвс бэлтгэхэд зарцуулж, малынхаа өвс тэжээлийн нөөцийг бэлтгэхэд эх үүсвэр болгож чадсан.
- ↑ Сүү цагаан идээ боловсруулж, төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хот, төвлөрсөн хүн амтай газруудад борлуулах, арга туршлага хуримтлуулсан.

**ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ**

А.Мөнхтуяа. Малчин

Би сүүлийн жилүүдэд гэр бүлээрээ малынхаа сүү саалийг боловсруулж, зах зээлд борлуулж байгаа. Энэ жил “Ногоон алт”-аас төсөл авч, үйл ажиллагаагаа нэмэгдүүлж ажилласан.

Малчин бидэнд бэлэн мөнгөний хэрэгцээ байнга тулгарч байдаг, хадлан өвсний цагаар төслийн санхүүжилт авч, цагаан идээ боловсруулах, борлуулах эргэлтэд оруулж, орлогоо олж ажилласан нь өвс хадлангаа бэлтгэхэд их тустай болсон.

Цаашид сүү, цагаан идээ боловсруулж, борлуулах ажлаа улам өргөжүүлж ажиллах бодол төлөвлөгөөтэй байгаа.

